

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 27-ны өдрийн
Б/ 01 дүгээр захирамжийн хавсралт

Ч.НЭРГҮЙН АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Цэнд-Аюуш	- Буянт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Гишүүд: Б.Батнасан	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Ч.Эрдэнэбат	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Д.Болортуяа	- Буянт сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга: Ш.Даваатогтох	- Буянт сумын Засаг даргын Тамгын газрын дарга

-оОо-



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар Б/01

Ховд

Ч.Нэргүйг албан тушаалаас
огцруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2.3, 65 дугаар зүйлийн 65.2 дахь заалт, Буянт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 4/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Буянт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 4/05 дугаар тогтоолоор хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхи нь тус сумын Засаг дарга Чойдогийн Нэргүйг огцруулах тухай санал ирүүлсэн тул Ч.Нэргүйг 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөр тасалбар болгон Буянт сумын Засаг даргын албан тушаалаас огцруулсугай.

2. Ч.Нэргүйн ажлыг хүлээлцүүлж, тооцоо хийх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ